



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/120

Арвайхээр

Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийг шуурхай зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, "а", Мал, амьтны эрүүл мэндийн хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх заалтыг үндэслэн, Монгол Улсын Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2021 оны "Хаваржилтын болшзошгүй хүндрэл, хүн малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх, отор нүүдлийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай" 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мал, амьтны сэг зэмийг устгах орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2021 оны 03 дугаар 10-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний хооронд харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, мал эмнэлгийн ариун цэврийн халдваргүйтгэлийн ажлыг шуурхай зохион байгуулж, арга хэмжээг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө гарган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т үүрэг болгосугай.

2. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах ажиллах хүч, унаа тээврийн болон бусад шаардлагатай зардлыг шийдвэрлэж, отор нүүдэл шилжилт хөдөлгөөн дамжин өнгөрөх чиглэл, хугацааг тогтоох ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хэсэг томилж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Арга хэмжээний хүрээнд орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг тухай бүр хэрэгжүүлж, хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Төв суурин газар, улс, аймгийн чанартай зам, малын бэлчээр, тариалангийн талбай, гол, горхи, булаг шандны орчимд мал, амьтны сэг зэмийг орхиж хаясан эх үүсвэрийг тогтоох, буруутай этгээдэд холбогдох хууль, журмын дагуу харицлага тооцож ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Баясгалан), аймгийн Автотээврийн төв (Д.Амартүвшин) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ